

**БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ  
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч бооцоот уралдааны үйл ажиллагааг хууль ёсоор, хариуцлагатай эрхлэх боломжийг бий болгох, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх нийтийн эрх зүйн этгээд буюу “Монголын морин уралдааны холбоо”-г байгуулах, түүний чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох, бооцоот уралдааны үйл ажиллагааг нээлттэй, хариуцлагатай, ил тод байдлаар зохион байгуулах, оролцогчдод тэгш боломж олгох, бооцоот морин уралдааны оролцогч, уяач, унаачийн эрх ашгийг тэнцвэртэй хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа төрлийн зардал үүсэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тодорхой зардал үүснэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир бооцоот морин уралдааны тусгай зөвшөөрлийг олгох байгууллага, унаачид эрсдэл гарсан тохиолдолд даатгалын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил морин спортын нэг холбоо байгуулж үндэсний наадам болон бооцоот морин уралдаан зохион байгуулах боломжтой эсэх, Хонг Конгийн бооцоот морин уралдааны клубтэй төстэй хувилбарыг сонгох болсон шалтгаан, давуу тал, морин тойруулга байгуулахад тооны хязгаарлалт байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх

талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Ц.МӨНХ-ОРГИЛ**